Улсын төсвөөс санхүүждэг байгууллагууд сарын эхэнд 1.1 тэрбум төгрөгийн өглөгтэй байснаас шинээр 2.1 тэрбум төгрөгийн өглөг үүсч, 1.7 тэрбум төгрөгийн өглөгийг төлж барагдуулан, сарын эцэст 1.5 тэрбум төгрөгийн өглөгтэй үлджээ.


НИЙГМИЙН ДААТГАЛЫН ҮЙЛЧИЛГЭЭ

2012 оны I улиралд нийслэлийн нийгмийн даатгалын салбарын үйлчилгээнд 327.7 мянган хүн хамрагдаж шимтгэл төлсөн ба тэдгээрийн 224.8 мянга буюу 68.6 хувь нь аж ахуйн нэгж байгууллагын, 73.2 мянга буюу 22.3 хувь нь төсөвт байгууллагын, 29.7 мянга буюу 9.1 хувь нь сайн дурын даатгуулагчид байна. Даатгуулагчийн тоо өмнөх оны мөн үеэс 18.9 хувиар буюу 52.1 мянган хүнээр нэмэгджээ.

Зураг 23. Даатгалын сангийн орлого, сая төгрөг



Зураг 24. Даатгалын сангийн зарлага, хувиар




Нийслэлийн нийгмийн даатгалын байгууллагууд 2012 оны I улиралд нийгмийн даатгалын шимтгэлийн орлогын төлөвлөгөөг 140.2 хувиар биелүүлж, даатгалын санд нийт 105.1 тэрбум төгрөг хуримтлуулсан байна. Даатгалын санд хуримтлуулсан нийт шимтгэлийн орлогын 64.7 хувь нь тэтгэврийн даатгалын санд, 19.0 хувь нь эрүүл мэндийн даатгалын санд, 4.3 хувь нь тэтгэмжийн даатгалын санд, 8.0 хувь нь үйлдвэрлэлийн осол мэргэжлээс шалтгаалах өвчний даатгалын санд, 4.0 хувь нь ажилгүйдлийн даатгалын санд тус тус төвлөрчээ.

Нийслэлийн нийгмийн даатгалын сангаас энэ улиралд даатгуулагч, иргэдэд 73.8 тэрбум төгрөгийн тэтгэвэр, тэтгэмж, төлбөр, сургалтын болон эмчилгээний зардал, эмийн үнийн хөнгөлөлт олгосон байна.

Нийт зардлын 71.2 хувийг тэтгэврийн, 17.9 хувийг эрүүл мэндийн, 2.7 хувийг ҮОМШӨ-ний, 7.1 хувийг тэтгэмжийн, 1.1 хувийг ажилгүйдлийн даатгалын сангаас олгосон зардал эзэлж байна. Тэтгэвэр, тэтгэмжийн даатгалын сангаас тэтгэвэр, тэтгэмж авагч иргэдийн тоо 3-р сард 120.1 мянга, олгосон тэтгэврийн хэмжээ өссөн дүнгээр 54.1 тэрбум төгрөгт хүрчээ. Нийт олгосон тэтгэврийн 69.4 хувийг өндөр насны, 8.9 хувийг хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн, 4.0 хувийг тэжээгчээ алдсаны, 14.3 хувийг цэргийн, 3.5 хувийг бусад тэтгэвэрт зарцуулсан байна.

ХҮН АМЫН АЖИЛ ЭРХЛЭЛТ Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн яамны сар бүрийн мэдээгээр дүүргийн хөдөлмөр, халамж үйлчилгээний хэлтэст бүртгэлтэй, ажил идэвхтэй хайж байгаа ажилгүй иргэдийн тоо нийслэл Улаанбаатар хотод 2012 оны 3 дугаар сарын эцэст 17993 болж, өмнөх оны мөн үеийнхээс 1.9 дахин буюу 8375 хүнээр өсчээ. Нийт ажилгүйчүүдийн 8971 буюу 49.9 хувь нь эмэгтэйчүүд байна.

Зураг 25. Дүүргийн ажилгүйчүүд, хотын дүнд



Насны бүлгээр авч үзвэл нийт бүртгэлтэй ажилгүйчүүдийн 21.1 хувь буюу 3794 нь 16-24 насны, 42.0 хувь буюу 7548 нь 25-34 насны, 21.0 хувь буюу 3784 нь 35-44 насны, 15.9 хувь буюу 2867 нь 45-59 насны хүмүүс байна.

Бүртгэлтэй ажилгүйчүүдийн 19.4 хувь буюу 3487 нь Сүхбаатар, 16.2 хувь буюу 2919 нь Сонгинохайрхан, 14.1 хувь буюу 2542 нь Баянгол, 13.8 хувь буюу 2487 нь Баянзүрх, 11.7 хувь буюу 2111 нь Хан-Уул, 10.5 хувь буюу 1892 нь Чингэлтэй, 10.4 хувь буюу 1868 нь Налайх, 2.3 хувь буюу 405 нь Багануур, 1.6 хувь буюу 282 нь Багахангай дүүрэгт тус тус амьдарч байна.

Хүснэгт 20. Ажилгүйчүүд, боловсролын түвшнээр /4-р сарын 1-ний байдлаар/

	Ажилгүйчүүдийн тоо			Дүнд эзлэх хувь		
	2010 он	2011 он	2012 он	2010 он	2011 он	2012 он
Нийт ажилгүйчүүд	7314	9618	17993	100	100	100
Үүнээс : дээд боловсролтой	1633	2545	7119	22.3	26.5	39.6
Тусгай дунд боловсролтой	377	649	1160	5.2	6.7	6.5
Мэргэжлийн анхан шатны боловсролтой	353	528	1285	4.8	5.5	7.1
Ерөнхий боловсролтой	4909	5852	8333	67.1	60.8	46.3
Мэргэжилгүй	42	44	96	0.6	0.5	0.5

2012 оны 3-р сард ажилгүй 2995 иргэн шинээр бүртгүүлж, бүртгэлтэй ажилгүй байсан 1020 иргэн ажилд зуучлагдан орж, 13291 иргэн ажил идэвхтэй хайхгүй байгаа шалтгаанаар бүртгэлээс хасагджээ. 2012 оны I улиралд 5563 хүн дүүргийн хөдөлмөр, халамж үйлчилгээний хэлтэст ажилд орохоор шинээр бүртгүүлсэн нь өмнөх оны мөн үеийнхээс 17.6 хувь буюу 834 хүнээр өсчээ.


2012 оны I улиралд 2406 хүн хөдөлмөр, халамж үйлчилгээний хэлтсээр зуучлуулан ажилд орсны 3.3 хувь нь улсын үйлдвэрийн газарт, 5.2 хувь нь төрийн төсөвт байгууллагад, 91.5 хувь нь компани, нөхөрлөл, хоршоо болон бусад газарт ажилд орсон байна.

НИЙСЛЭЛ ХОТЫН АЮУЛГҮЙ БАЙДАЛ

2012 оны I улиралд 3241 гэмт хэрэг бүртгэгдсэн нь өмнөх оны мөн үеэс 13.0 хувь буюу 374 хэргээр өсчээ.

Гэмт хэргийн илрүүлэлт 51.6 хувьтай байгаа нь өмнөх оны мөн үеэс 4.0 пунктээр доогуур байна. Гэмт хэргийн улмаас 1119 хүн гэмтэж осолдсоноос 16.0 хувь нь буюу 179 хүн нас барж, төр ард иргэдэд 11.3 тэрбум төгрөгийн хохирол учруулсны 15.6 хувь буюу 1.8 тэрбум төгрөгийн хохирлыг нөхөн төлүүлжээ.

Зураг 26. Бүртгэгдсэн гэмт хэрэг, сараар



Хүснэгт 21. Бүртгэгдсэн гэмт хэрэг, төрлөөр, эхний 3 сард

	Гэмт хэргийн тоо		Өсөлт, бууралт	
	2011 он	2012 он	Тоо	Хувь
Хүний амь	28	39	11	39.3
Хүчин	41	37	- 4	- 9.8
Дээрэм	119	131	12	10.1
Хулгай	689	874	185	26.9
Булаалт	36	33	- 3	- 8.3
Залилан	160	230	70	43.8
Хүний эрх, эрх чөлөөний эсрэг	839	855	16	1.9
Хөдөлгөөний аюулгүй байдал ашиглалтын журам зөрчих	202	241	39	19.3
Бусдыг амиа хорлоход хүргэх	164	122	- 42	- 25.6
Ашиглах	27	34	7	25.9
Танхайрах	345	308	- 37	- 10.7
Бусад	217	337	120	55.3
БҮГД	2867	3241	374	13.0

Бүртгэгдсэн гэмт хэргийн 27.0 хувийг хулгайн, 7.1 хувийг залилан, 7.4 хувийг тээврийн хэрэгслийн хөдөлгөөний аюулгүй байдал ашиглалтын журмын эсрэг, 9.5 хувийг танхайн, 26.4 хувийг хүний эрх, эрх чөлөөний эсрэг хэрэг тус тус эзэлж байна.

2012 оны эхний 3 сард 16609 хүн эрүүлжигдсэн нь өмнөх оны мөн үеэс 2.9 хувь буюу 494 хүнээр буурсан байна.

Гэмт хэрэгт холбогдсон сэжигтэн, яллагдагчдын тоо 2592 болж, 2011 оны мөн үеэс 11.7 хувь буюу 272 хүнээр өссөн байна.

Гэмт хэрэгт холбогдсон нийт сэжигтэн, яллагдагчдын

14.4 хувь буюу 374 нь гэмт хэргийг бүлэглэн үйлдсэн, 16.8 хувь буюу 435 нь согтуугаар үйлдсэн, 5.2 хувь буюу 136 нь урьд ямар нэг ял шийтгэл хүлээж байсан хүмүүс үйлджээ. Сэжигтэн, яллагдагчдын 7.5 хувь буюу 195 нь хүүхэд, 17.1 хувь буюу 442 нь эмэгтэйчүүд байна.

2012 оны эхний 3 сард хүнд хэрэг 330, хөнгөн хэрэг 1288, хүндэвтэр хэрэг 1533, онц хүнд хэрэг 90 бүртгэгдсэн нь өмнөх оны мөн үеэс 8.9-42.9 хувиар тус тус өссөн байна.

Хүснэгт 22. Бүртгэгдсэн гэмт хэрэг, дүүргээр, эхний 3 сард

	Бүртгэсэн гэмт хэрэг		Өсөлт, бууралт		Сэжигтэн тодорхойгүй хэрэг	Үүнээс: ял сонгосон	Илрүүлэлтийн хувь	Өмчийн хулгай			
								Бүгд		Иргэдийн	
	2011 он	2012 он	тоо	хувь				2011 он	2012 он	2011 он	2012 он
Багануур	48	74	26	54.2	11	7	63.6	12	7	8	2
Багахангай	1	7	6	7.0 дах	1	-	-	-	2	-	2
Баянгол	540	637	97	18.0	194	99	51.0	144	179	112	156
Баянзүрх	604	627	23	3.8	313	133	42.5	121	185	103	160
Налайх	77	70	- 7	- 9.1	15	10	66.7	7	12	4	9
Сонгинохайрхан	511	542	31	6.1	210	116	55.2	158	167	150	148
Сүхбаатар	430	569	139	32.3	201	108	53.7	93	148	78	130
Чингэлтэй	395	436	41	10.4	162	106	65.4	85	96	60	78
Хан-Уул	261	279	18	6.9	96	42	43.8	69	78	63	73
ДҮН	2867	3241	374	13.0	1203	621	51.6	689	874	578	758

Зураг 27. Гэмт хэргийн тоо, ангиллаар



ЭРҮҮЛ МЭНД 2012 оны эхний 3 сард 8393 хүүхэд мэндэлсэн нь өмнөх оны мөн үеэс 1064 хүүхдээр олон байна. Шинээр мэндэлсэн нийт хүүхдийн 13.3 хувь буюу 1117 нь бусад аймгийн харъяат эхчүүдээс төрсөн байна.


Хүснэгт 23. Төрсөн хүүхэд, эх, хүүхдийн эндэгдэл, эхний 3 сард

	2010 он	2011 он	2012 он	$\frac{2012}{2011}$ %
Амаржсан эхийн тоо	7472	7299	8348	114.4
Амьд төрсөн хүүхэд	7514	7329	8393	114.5
Эхийн эндэгдэл	2	6	5	83.3
Төрсөн 1000 эх тутмаас эндсэн эх	0.27	0.82	0.59	72.0
Нэг хүртэл насандаа эндсэн хүүхэд	127	114	104	91.2
Амьд төрсөн 1000 хүүхэд тутмаас 1 хүртэл насанд эндсэн хүүхэд	16.90	15.55	12.39	79.7

Нялхсын эндэгдлийн 13.7 хувь буюу 10 нь Баянгол, 15.1 хувь буюу 11 нь Баянзүрх, 26.0 хувь буюу 19 нь Сонгинохайрхан, 8.2 хувь буюу 6 нь Сүхбаатар, 11.0 хувь буюу 8 нь Хан-Уул, 9.6 хувь буюу 7 нь Чингэлтэй, 12.3 хувь буюу 9 нь Налайх, 4.1 хувь буюу 3 нь Багануур дүүрэгт тус тус гарсан байна.

Нялхсын эндэгдлийн 26.9 хувь буюу 28 нь бусад аймгийн харъяат байна. Өмнөх оны мөн үеэс нялхсын эндэгдэл 3.16 промилээр буурчээ.

Зураг 28. Халдварт өвчнөөр өвчлөгсөд



Нийслэлд 2012 оны эхний 3 сард 5638 хүн халдварт өвчнөөр өвчилсөн нь өмнөх оны мөн үеэс 45.8 хувь буюу 1770 хүнээр, 10000 хүн тутмаас халдварт өвчнөөр өвчилсөн хүний тоо 13.51 продицимилээр тус тус өсчээ. Халдварт өвчнөөр өвчлөгс-дийн 17.6 хувийг халдварт шар, 26.5 хувийг гахай хавдар, 8.5 хувийг салхинцэцэг, 10.4 хувийг тэмбүү, 8.4 хувийг заг хүйтэн, 8.2 хувийг трихомониаз, 10.3 хувийг сүрьеэ өвчнөөр өвчлөгсөд тус тус эзэлж байна.

Хүснэгт 24. Нийслэлд гарсан халдварт өвчин, эхний 3 сард

	хэмжих нэгж	2011 он	2012 он	өсөлт, бууралт	
				тоо/пункт	хувиар
Халдварт өвчнөөр өвчилсөн бүх хүн, үүнээс	бодит тоо	3868	5638	1770	45.8
	10000 хүнд	34.10	47.61	13.51	
Вируст гепатит	бодит тоо	916	995	79	8.6
	10000 хүнд	8.08	8.40	0.32	
Менингит	бодит тоо	5	5	-	-
	10000 хүнд	0.04	0.04	-	
Цусан суулга	бодит тоо	277	220	- 57	- 20.6
	10000 хүнд	2.44	2.60	0.16	
Гахай хавдар	бодит тоо	76	1492	1416	19.6 дах
	10000 хүнд	0.67	12.59	11.92	
Салхин цэцэг	бодит тоо	571	479	- 92	- 16.1
	10000 хүнд	5.03	4.04	- 0.99	
Улаан эсэргэнэ	бодит тоо	8	26	18	3.3 дах
	10000 хүнд	0.07	0.22	0.15	
Хоолны хордлого	бодит тоо	11	19	8	1.7 дах
	10000 хүнд	0.10	0.16	0.06	
Ёлом	бодит тоо	14	23	9	1.6 дах
	10000 хүнд	0.12	0.16	0.04	
Улаанууд	бодит тоо	-	19	19	-
	10000 хүнд	-	0.16	0.16	
Сальмонеллэз	бодит тоо	14	6	- 8	- 2.3 дах
	10000 хүнд	0.12	0.05	- 0.07	
Бруцеллэз	бодит тоо	35	10	- 25	- 3.5 дах
	10000 хүнд	0.31	0.08	- 0.23	
Нярайн халдвар	бодит тоо	1	2	1	2.0 дах
	10000 хүнд	0.01	0.02	0.01	
Гар хөл амны өвчин	бодит тоо	51	102	51	2.0 дах
	10000 хүнд	0.45	1.20	0.75	
Тэмбүү	бодит тоо	530	585	55	10.4
	10000 хүнд	4.67	4.94	0.27	
Заг хүйтэн	бодит тоо	382	475	93	24.3
	10000 хүнд	3.37	4.01	0.64	
Трихомониаз	бодит тоо	333	461	128	38.4
	10000 хүнд	2.94	3.89	0.95	
Шинээр илэрсэн сүрьеэ	бодит тоо	598	580	- 18	- 3.0
	10000 хүнд	5.27	4.90	- 0.37	
ДОХ	бодит тоо	7	5	- 2	- 28.6
	10000 хүнд	0.06	0.04	- 0.02	

НИЙТИЙН ЗОРЧИГЧ ТЭЭВРИЙН ҮЙЛЧИЛГЭЭ

2012 оны I улиралд Улаанбаатар хотын дотор болон хот орчмын нийт 4.2 мянга гаруй км урт бүхий 129 чиглэлд 75 аж ахуйн нэгж, байгууллага нийтийн тээврийн үйлчилгээг үзүүлсэн байна.

Нийтийн тээврийн үйлчилгээ үзүүлэгч ААНБ-ууд 2012 оны I улиралд 60.5 сая хүн тээвэрлэж, 205.7 сая хүн километрийн ажил үйлчилгээг гүйцэтгэн, 21.7 тэрбум төгрөгийн орлоготой ажиллажээ. Өнгөрсөн оны мөн үеэс зорчигчдын тоо 5.9 хувиар буурч, үйлчилгээний орлого 29.2 хувиар буюу 4.9 тэрбум төгрөгөөр тус тус өссөн байна.

Зураг 29. Зорчигч тээврийн үйлчилгээ эрхэлж аж ахуйн нэгжийн тоо




Зураг 30. Зорчигч тээврийн буй чиглэлийн урт



Өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад нийтийн тээврийн үйлчилгээ эрхэлж байгаа аж ахуйн нэгжийн тоо 21 хувиар, үүний дотор бага багтаамжийн автобус бүхий аж ахуйн нэгжүүд 23.4 хувиар, такси үйлчилгээний аж ахуйн нэгжүүд 31.8 хувиар тус тус буурсан нь тээвэрлэсэн зорчигчдын тоо өнгөрсөн оны мөн үеэс буурахад нөлөөлсөн.

Зураг 31. Үйлчилгээний орлого, тэрбум төг төлбөрийн хэлбэрээр



Зураг 32. Зорчигчдын тоо, сая хүн төлбөрийн хэлбэрээр



Нийтийн зорчигч тээврийн үйлчилгээний нийт орлогын 48.3 хувийг шугамын орлого бүрдүүлж, нийтийн тээврийн хэрэгслээр зорчигчдын 53.6 хувь нь билет худалдан авч үйлчлүүлжээ. Үйлчилгээний нийт орлогын 55.3 хувийг их, дунд багтаамжийн автобус бүхий хувийн хэвшлийн аж ахуйн нэгжүүд бүрдүүлсэн байгаагийн 62.5 хувийг нь нөхөн олговрын орлого эзэлж байна. 2012 оны I улиралд тээвэрлэсэн нийт зорчигчдын 39.0 хувийг төрийн өмчийн 3 аж ахуйн нэгж тээвэрлэсэн бөгөөд билет

худалдан авч үйлчлүүлсэн нийт зорчигчдын 44.1 хувь нь дээрх аж ахуйн нэгжүүдэд ногдож байна.

2012 оны I улиралд нийтийн тээврийн үйлчилгээний парк шинэчлэлт их багтаамжийн автобус болон таксины үйлчилгээнд хийгдэж, 246 тээврийн хэрэгсэл үйлчилгээнд шинээр гарч, нийтийн тээврийн үйлчилгээний стандартын шаардлага хангахгүй болж, 12-оос дээш жилээр ашиглагдаж хуучирсан 145 тээврийн хэрэгсэл (хувийн хэвшлийн их багтаамжийн 4 автобус, бага оврын 75 автобус, 66 такси) үйлчилгээнээс хасагджээ.

Зураг 33. Өдөрт ажилласан тээврийн хэрэгсэл Хүснэгт 25. Автобусны буудал, зогсоолын тоо



Дүүрэг	2012 оны I улиралд	
	Нийт зогсоол	Үүнээс: Эцсийн зогсоол
Хан-Уул	84	10
Баянзүрх	140	24
Баянгол	61	6
Сүхбаатар	53	5
Чингэлтэй	119	14
Сонгинохайрхан	143	25
Нийт	600	84

Нийслэл хотын дотор зорчих их багтаамжийн автобусны дундаж хурдны графикт хугацааг 19км/цагаар тогтоосон байдаг боловч Энхтайвны өргөн чөлөөний баруун дөрвөн замаас зүүн дөрвөн замын уулзварын хооронд оргил ачаалын үед дундаж хурд буурч 10-11 км/цагт хүрээд байна.

Зураг 34. Хүлээлтийн хугацаа, минут




Нийтийн тээврийн үйлчилгээний “үндсэн чиглэл”-ийн хүлээлтийн хугацаа тогтмолжих хандлагатай байгаа хэдий ч зогсоолд ирэх автобус хоорондын зай буюу хүлээлтийн дундаж хугацааг өмнөх оны мөн үетэй харьцуулахад их, дунд багтаамжийн автобусных 0.3 минутаар, бага оврын автобусных 0.8 минутаар тус тус нэмэгдэж, троллей-бусны хүлээлтийн хугацаанд өөрчлөлт гараагүй байна

Нийслэлийн Нийтийн Тээврийн газраас аж ахуйн нэгж байгууллагуудтай байгуулсан “нийтийн тээврийн үйлчилгээг эрхлэн гүйцэтгүүлэх тухай гэрээ”-нд заасан үнэ тарифын дагуу насанд хүрэгчид их, дунд багтаамжийн автобусанд 400 төгрөг, троллейбусанд 200 төгрөг, туслах болон буухиа чиглэлийн бага оврын автобусанд 400-600 төгрөг, хот орчмын чиглэлийн бүх төрлийн автобусанд эргэлтийн уртаас хамааран 500-2200 төгрөгөөр (хүүхэд 200-1200 төгрөг) зорчиж байна. Дээрх гэрээнд таксины үйлчилгээний нэг километрийн тарифийг 600 төгрөгөөр тогтоож, мөрдүүлэхээр заасан байна.

Нийслэлийн Нийтийн Тээврийн газарт зорчигч тээврийн үйлчилгээний талаар иргэдээс 2012 оны I улиралд дараах төрлийн нийт 234 санал гомдол ирсний 98.7 хувийг нь шийдвэрлэж, барагдуулсан байна. Үүнд:

- 5 гомдол буюу 2.1 хувь нь хөнгөлөлтийн “2012” үнэмлэхээр явуулаагүй тухай,
- 168 буюу 71.8 хувь нь үнэ тарифтай холбоотой, оюутны хөнгөлөлтийн картаар үйлчлээгүй, хүүхэд суулгаагүй, тасалбар олгоогүй, өртөөчилж үнэ тариф зөрчсөн, маршрут зөрчсөн, буудал дээр зогсоогүй, буудал зарлаагүй, цагийн хуваарь мөрдөөгүй тухай,
- 17 буюу 7.3 хувь нь даац хэтрүүлсэн, стандартын шаардлага хангаагүй тээврийн хэрэгслээр үйлчилсэн, замын хөдөлгөөнд хөдөлгөөний аюулгүй байдлыг хангаагүй оролцсон тухай,
- 44 буюу 18.8 хувь нь жолооч, мөнгө хураагчдын зан харьцаа, үйлчилгээний соёл, тээврийн хэрэгслийн цэвэрлэгээ, өнгө үзэмж тааруу тухай

Зураг 35. Үйлчилгээний талаар ирүүлсэн санал гомдлын шийдвэрлэлт



ХАРИЛЦАА ХОЛБОО

Шуудан, холбоо, интернэтийн үйлчилгээний орлого 2012 оны I улиралд 120.7 тэрбум төгрөг болж, өмнөх оны мөн үеэс 26.1 тэрбум төгрөг буюу 27.6 хувиар өсчээ. Нийт орлогын 77.5 хувь буюу 93.5 тэрбум төгрөгийг хүн амд үзүүлсэн үйлчилгээнээс бүрдүүлсэн байна.


Нийслэлд суурин телефон цэгийн тоо 2012 оны эхний улиралд 106.0 мянга болж, өмнөх оны мөн үеэс 19.6 хувиар нэмэгджээ.

Хүснэгт 26. Холбооны салбарын үндсэн үзүүлэлт

	Хэмжих нэгж	2011.I-III	2012.I-III
Нийт орлого	сая төг	94584.0	120712.6
Үүнээс: хүн амаас	сая төг	76703.0	93575.6
Суурин телефон цэг	мянган ширхэг	88620	106021
Үүнээс: айл өрхийн		58088	70231
Утасгүй телефон	тоо	28416	29821
Үүрэн телефон хэрэглэгч	мянган хүн	2079.2	2117.5
КаТВ-ийн хэрэглэгч	тоо	86535	154027

Нийт суурин телефон цэгийн 70.2 мянга буюу 66.2 хувь нь өрхийн эзэмшилд ашиглагдаж байгаа бөгөөд өмнөх оны мөн үетэй харьцуулахад 20.9 хувиар өссөн байна. Энэ нь зах зээлд гурвалсан үйлчилгээ бүхий суурин утасны шинэ үйлчилгээ нэвтэрсэнтэй холбоотой.

Зураг 36. Суурин телефон цэгийн тоо




Зураг 37. Үүрэн холбооны хэрэглэгчийн тоо



2012 оны эхний улиралд Монгол Улсын хэмжээнд давхардсан тоогоор нийт 2.9 сая гаруй хүн үүрэн телефон хэрэглэж байгаагийн 70.9 хувь буюу 2.1 сая гаруй хэрэглэгч нь нийслэл хотод байна.

Нийт хэрэглэгчдийн 277.8 мянга нь дараа төлбөрт үйлчилгээний, 1839.6 мянга нь урьдчилсан төлбөрт үйлчилгээний хэрэглэгчид байна. Түүнчлэн нийслэлд 29.8 мянган хэрэглэгч хөдөлгөөнт утасгүй телефон буюу WLL үйлчилгээг, 0.8 мянган хэрэглэгч сансарын холбоог эзэмшиж байна.

Зураг 38. КаТВ, сувагт холбогдсон хэрэглэгчийн тоо



2012 оны I улиралд кабелийн телевизийн үйлчилгээг 16 аж ахуйн нэгж эрхэлж, нийслэлийн 154.0 мянган хэрэглэгчдэд үйлчилсэн байна.

Нийт хэрэглэгчийн 96.2 хувийг айл өрх эзэлж байна.

Кабелийн телевизийн үйлчилгээ үзүүлэгч аж ахуйн нэгжүүдийн 12 нь нийслэлийн төвийн 6 дүүрэгт 32-63 хүртэл

сүвгаар, алслагдсан дүүргүүдэд 4 аж ахуйн нэгж 24-35 сүвгаар нэвтрүүлгээ тогтмол цацаж үйлчилжээ. Кабелийн телевизийн сувагт холбогдох хураамж өрхөд 10.0-20.0 мянган төгрөг, үйлчилгээний төлбөрийн сарын хураамж нь 3000-6000 төгрөг байв.

МАЛ ТӨЛЛӨЛТ, ТӨЛ БОЙЖИЛТ

2012 оны I улиралд нийслэл хотын хэмжээнд нийт хээлтэгч малын 32.7 хувь буюу 43604 хээлтэгч төллөжээ. Нийт 43670 төллөсөн эх малаас 394 төл мал хоргодож, 43276 төл бойжиж байна. Төл бойжилт 99.1 хувьтай байгаа нь өмнөх оны мөн үеэс 0.1 пунктээр буурсан байна.

Хүснэгт 27. Төл бойжилт, толгой

Дүүрэг	Төллөсөн хээлтэгч	Гарсан төл	Хорогдсон төл	Бойжсон төл	Төл бойжилт, хувь
Багануур	6656	6666	133	6533	98.0
Багахангай	1604	1608	-	1608	100.0
Баянгол	5	5	-	5	100.0
Баянзүрх	4853	4853	84	4769	98.3
Налайх	2390	2390	8	2382	99.7
Сонгинохайрхан	25048	25098	152	24946	99.4
Сүхбаатар	344	346	1	345	99.7
Хан-Уул	2461	2461	15	2446	99.4
Чингэлтэй	243	243	1	242	99.6
Дүн	43604	43670	394	43276	99.1

Мал төллөлтийн мэдээг өмнөх оны мөн үетэй харьцуулахад төллөсөн хээлтэгч 24793 толгой буюу 2.3 дахин, бойжсон төл 24646 толгой буюу 2.3 дахин, төл малын хорогдол 2.1 дахин өсчээ. Нийт бойжсон төлийн 0.03 хувийг ботго, 0.9 хувийг унага, 10.2 хувийг тугал, 45.9 хувийг хурга, 43.0 хувийг ишиг эзэлж байна.

Хүснэгт 28. Төл бойжилт, толгой

Үзүүлэлт	2011 I улирал	2012 I улирал	Үүнээс:				
			ингэ	гүү	үнээ	хонь	ямаа
Төллөсөн хээлтэгч	18811	43604	15	382	4479	19984	18744
Гарсан төл	18817	43670	15	382	4480	20022	18771
Хорогдсон төл	187	394	-	14	72	150	158
Бойжсон төл	18630	43276	15	368	4408	19872	18613

ТОМ МАЛЫН ЗҮЙ БУС ХОРОГДОЛ 2012 оны I улиралд нийслэлд 651 толгой том мал зүй бусаар хорогдсоны 39.8 хувь буюу 259 нь өвчнөөр хорогджээ.

Хүснэгт 29. Том малын зүй бус хорогдол

Дүүрэг	Бүгд	Үүнээс:				
		тэмээ	адуу	үхэр	хонь	ямаа
Багануур	354	1	35	41	114	163
Багахангай	29	-	-	1	15	13
Баянзүрх	30	-	6	8	8	8
Налайх	64	-	-	5	23	36
Сонгинохайрхан	136	-	4	31	60	41
Сүхбаатар	7	-	-	6	-	1
Хан-Уул	26	-	2	6	8	10
Чингэлтэй	5	-	-	5	-	-
Дүн	651	1	47	103	228	272

Хорогдсон нийт малын 30.4 хувийг хээлтэгч мал эзэлж байна. Зүй бусаар хорогдсон малын 0.5 хувийг тэмээ, 1.0 хувийг адуу, 15.2 хувийг үхэр, 34.8 хувийг хонь, 48.5 хувийг ямаа эзэлж байна.

Нийслэлийн хэмжээнд малын зүй бус хорогдол өмнөх оны мөн үеэс 31.6 хувиар буурчээ.

АМЬДАРЧ БУЙ ОРЧИН Нийслэлийн хэмжээнд 2012 оны I улиралд байгаль орчныг хамгаалах хууль, тогтоомжийг зөрчсөн 138 зөрчлийг илрүүлжээ. Зөрчлийн тоо өмнөх оны мөн үеэс 1.4 дахин буурсан бөгөөд нийт зөрчлийн 44.2 хувийг ургамал, хөрсний бохирдлын зөрчил, 26.1 хувийг ойн зөрчил, 17.4 хувийг агаар, химийн хорт бодисын зөрчил эзэлж байна. Илрүүлсэн зөрчилд 8.2 сая төгрөгийн торгууль ногдуулж, 850.0 мянган төгрөгийн нөхөн төлбөр төлөгджээ.

Хүснэгт 30. Байгаль орчны зөрчил

Илрүүлсэн зөрчил төрлөөр	2011 оны I улирал			2012 оны I улирал		
	Үзлэг шалгалт	Илрүүлсэн зөрчил	Торгууль /мян.төг/	Үзлэг шалгалт	Илрүүлсэн зөрчил	Торгууль /мян.төг/
Ой	60	43	4460.0	42	36	3700.0
Ангийн	-	-	-	-	-	-
Усны	31	18	250.0	-	-	-
Газрын	29	21	700.0	18	15	1844.4
Ургамал, хөрсний бохирдол	75	75	-	72	61	1416.4
Агаар, химийн хорт бодисын	54	26	-	31	24	1042.4
Газрын хэвлий, ашигт малтмал, уул уурхай	3	6	60.0	-	-	-
Геодези зураг зүй, кадастр	8	2	100.0	2	1	-
Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээ	10	2	-	1	1	200.0
Бусад	5	2	-	-	-	-
Бүгд	275	195	5570.0	166	138	8203.2


Нийслэлийн цаг агаар 2012 оны 3 сард дунджаар -8.0°C байв. Энэ нь өнгөрсөн оны мөн үеэс -1.6°C -аар дулаан, олон жилийн дундажтай харьцуулахад -0.4°C -аар хүйтэн байв. Энэ сард хамгийн дулаан өдөр нь 14.0°C , хамгийн хүйтэн өдөр нь -23.9°C , хур тунадасны нийлбэр 0.9 мм, салхины үнэмлэхүй их хурд 17 м/секунд хүрсэн байна.

Хүснэгт 31. Нийслэлийн гадаргын усны найрлага, мг/м³, 3 сард


	Стандарт хэмжээ	“Туул- Налайх” харуул цэг		“Туул-Сонгино доод” харуул цэг	
		хэмжээ	Бодисын хэтрэлт	хэмжээ	Бодисын хэтрэлт
Хүчилтөрөгч (O ₂)	≥6	6.04	-	0.39	Онцгой их бохирдсон
Биохимийн хэрэгцээт хүчилтөрөгч (БХХ ₅)	≤ 3	2.00	-	137.5	45.8 дахин
Нитритийн нэгдэл (NO ₂)	≤ 0.02	0.002	-	1.170	55.4 дахин
Амоны азот (NH ₄)	≤0.5	0.04	-	19.45	38.9 дахин
Эрдэс фосфор (P)	≤0.1	0.018	-	0.964	9.6 дахин

Туул голын усны найрлага Туул-Налайх харуул цэгт бохирдуулагч бодисын хэмжээ зөвшөөрөгдөх хэмжээнд, Туул-Сонгино доод харуул цэгийн орчимд хүчилтөрөгчийн горим алдагдаж онцгой бохирдолтой, биохимийн хэрэгцээт хүчилтөрөгч /БХХ₅/ 45.8 дахин, нитридийн нэгдэл /NO₂/ 55.4 дахин, амони азот /NH₄/ 38.9 дахин, эрдэс фосфор /P/ 9.6 дахин хэтэрч Туул голын ус бохирдолтой хэвээр байна.

Зураг 39. Хүхэрлэг хийн агууламж, мг/м³




Зураг 40. Азотын давхар ислийн агууламж, мг/м³




Хүснэгт 32. Агаарын бохирдолт, мг/м³

Бодисын нэр	Стандарт хэмжээ	Хийсэн ажиглалтын тоо	Хамгийн их хэмжээ	Стандарт хэмжээнээс давсан тохиолдол /тоо/	Агаарт байсан дундаж хэмжээ
Хүхэрлэг хий /SO ₂ /	0.020	169	0.090	147	0.038
Азотын давхар исэл /NO ₂ /	0.040	145	0.083	55	0.036
Тоосжилт /PM ₁₀ /	0.100	127	2.562	115	0.209
Тоосжилт /PM _{2.5} /	0.050	31	0.124	26	0.082
Угаарын хий /CO ₂ /	1.5	386	10.584	1	1.483
Озон /O ₃ /	0.100	210	0.097	-	0.021

Зураг 41. Нүүрстөрөгчийн дутуу исэл, мг/м³



Зураг 42. Тоосны /PM₁₀/ агууламж, мг/м³



Хүснэгт 33. Агаар дахь бохирдуулагч бодисын хоногийн дундаж агууламж, 3 сард мг/м³

Агаарын бохирдлын үзүүлэлт		Мишээл экспо	Баруун дөрвөн зам	1-р хороолол	13-р хороолол	32-ын тойрог	Офицеруудын ордон	Хархорин зах
Хүхэрлэг хий SO ₂	Дундаж	0.039	0.043	0.033	0.039	0.056	0.030	0.025
	Хамгийн их	0.083	0.076	0.059	0.071	0.090	0.058	0.042
	XXX*-с давсан хувь	92.3	93.5	88.5	83.9	100.0	75.0	74.2
	Хэмжилтийн тоо	13	31	26	31	25	12	31
Азотын давхар исэл NO ₂	Дундаж	0.018	-	0.033	0.064	0.032	0.029	0.040
	Хамгийн их	0.023	-	0.059	0.083	0.041	0.046	0.054
	XXX*-с давсан хувь	-	-	23.1	100.0	4.0	8.3	51.6
	Хэмжилтийн тоо	20	-	26	31	25	12	31
Нүүрстөрөгчийн дутуу исэл, CO ₂ **	Дундаж	1.634	1.790	-	1.361	2.062	-	0.566
	Хамгийн их	10.584	4.813	-	3.375	4.625	-	6.250
	XXX*-с давсан хувь	2.6	-	-	-	-	-	-
	Хэмжилтийн тоо	38	93	-	88	79	-	88
Тоос PM10	Дундаж	0.066	0.161	-	0.166	0.364	-	0.290
	Хамгийн их	0.094	0.359	-	0.318	0.866	-	2.562
	XXX*-с давсан хувь	-	93.5	-	96.8	100.0	-	100.0
	Хэмжилтийн тоо	9	31	-	31	25	-	31
Тоос PM2.5	Дундаж	-	0.082	-	-	-	-	-
	Хамгийн их	-	0.124	-	-	-	-	-
	XXX*-с давсан хувь	-	83.9	-	-	-	-	-
	Хэмжилтийн тоо	-	31	-	-	-	-	-
Озон O ₃	Дундаж	0.031	-	-	0.014	0.018	-	-
	Хамгийн их	0.097	-	-	0.036	0.053	-	-
	XXX*-с давсан хувь	-	-	-	-	-	-	-
	Хэмжилтийн тоо	41	-	-	89	80	-	-

* - Хүлцэх хэм хэмжээ

**- CO₂, O₃ -ийн хэмжилтийг 8 цагийн дунджаар тооцсон

ХОТ ТОХИЖИЛТ 2012 оны I улиралд тохижилтын ажилд 246.9 сая төгрөгийг зарцуулжээ. Тохижилтын ажилд зарцуулсан нийт хөрөнгийн 22.9 хувь буюу 56.5 сая төгрөгийг нийслэлийн төсвөөс, 77.1 хувь буюу 190.4 сая төгрөгийг дүүргийн төсвөөс санхүүжүүлсэн байна. Нийтийн эзэмшлийн зам талбайд 179 метр урт хайс хамгаалалт, 2.0 км урт гэрэлтүүлэг хийж 91.7 сая төгрөг зарцуулсан бөгөөд гэрэлтүүлгийн асалт дунджаар 86.0 хувьтай байлаа. Цэцэрлэгжилт компани 40.0 мянган м² зүлэг, 305 ширхэг мод, 209 ширхэг сөөг арчилж тордон, энэ ажилд 17.4 сая төгрөгийг зарцуулжээ. Хотын цэвэрлэгээний ажлаар 107.5 мянган тонн хог тээвэрлэж, 106.4 мянган тонн хогийг дарж устгасан байна. Дарж устгасан хогны 27.7 хувийг орон сууцны хороолоос, 46.6 хувийг гэр хороолоос, 23.8 хувийг аж ахуйн нэгж байгууллагаас, 1.9 хувийг зам талбайгаас гарсан хог эзэлж байна. 2012 оны I улиралд Хот тохижилтын газар нийтдээ 20625 золбин нохойг устгаж, энэ ажилд 103.1 сая төгрөг зарцуулсан байна.

НИЙТИЙН АЖ АХУЙН ҮЙЛЧИЛГЭЭ Нийслэлийн хүн амд 2012 оны I улиралд 8.3 сая м³, аж ахуйн нэгж, байгууллагад 2.5 сая м³ цэвэр усыг борлуулжээ. Цэвэрлэх байгууламжаар 13.6 сая м³ бохирыг цэвэрлэж, аж ахуйн нэгж, байгууллага, өрхийн 10.5 сая м³ бохир шингэнийг татан зайлуулсан байна. Хүн амд түгээсэн цэвэр усны 96.4 хувь буюу 7.9 сая м³-ыг нь төвлөрсөн шугамаар, 298.9 мянган м³ цэвэр усыг 591 түгээх байраар, 1.9 мянган м³ усыг тээврээр түгээсэн байна.

Хүснэгт 34. Ус суваг ашиглалтын үйлчилгээ

Үзүүлэлт	Хэмжих нэгж	2011 он III сар	2012 он III сар	2012/ 2011 %
Шахсан ус	мян.м ³	14006.6	13884.2	99.1
Борлуулсан ус	мян.м ³	10489.5	10770.0	102.7
Хүн амд	мян.м ³	8297.9	8267.5	99.6
ААНБ-д	мян.м ³	2191.6	2502.5	114.2
Татан зайлуулсан бохир	мян.м ³	10356.7	10536.4	101.7
Хүн амаас	мян.м ³	7885.2	7780.5	98.7
ААНБ-аас	мян.м ³	2471.5	2755.9	111.5
Ус борлуулалтын орлого	сая төг	3441.8	3648.4	106.0
Хүн амаас	сая төг	2227.6	2246.2	100.8
ААНБ-аас	сая төг	1214.2	1402.2	115.5
Сувагжуулалтын орлого	сая төг	1961.5	2044.7	104.2
Хүн амаас	сая төг	1160.5	1145.3	98.7
ААНБ-аас	сая төг	801.0	899.4	112.3

Энэ удаагийн дугаарыг Нийслэлийн Статистикийн газрын мэргэжилтэн Н.Байгалмаа эрхлэн гаргав.